

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

Б.РИНЧЕН - 110 ЖИЛИЙН ОЙ

**ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН
ИЛТГЭЛИЙН ЭМХЭТГЭЛ**

Эмхэтгэсэн: Б.Лхагважав

Хариуцлагатай редактор: Академич Л.Болд

АКАДЕМИЧ РИНЧЕН БОЛ ХҮНИЙ ТӨЛӨӨ ТӨРСӨН ХҮН

“Хүний” гэдэг үгийг монгол худам үгээр *ᠬᠦᠨᠢ* * *küniin-ü*, *ᠬᠦᠨᠢ* *künei* гэж хоёр янз бичдэг. Сүүлийнх нь “бусдын”, “түмний”, “олны”, “өрөөлийн” гэсэн утгатай. Илтгэгч, энэхүү санааг тэтгэн “Академич Ринчен бол, хүний төлөө төрсөн хүн” гэсэн номынхоо:

Академич Ринчен бол:

- Мутаргаа номын үсэг атгаж төрсөн, **Өвчүү нимгэн** (*ᠥᠪᠴᠦᠭᠦ ᠨᠢᠮᠭᠡᠨ* *ebčigüü nimgen*=эрдэм төгс) **хүн** байсан,
- Өөрийгөө боддоггүй, **өр зөөлөн** (*ᠥᠷ ᠵᠡᠭᠡᠯᠡᠨ* *ör jögeleᠨ*=өрөвч) **хүн** байсан,
- Муулуулж байсан ч муу болоодүй, хиртэх нь байтугай, тортог ч суугаагүй, **хүн**,
- Гангар шаазан шиг хэврэг харагдсан ч, ган төмөр шиг хат суусан, гутаа нь үгүй сэтгэлтэн бөлгийн хэсгээс толилуулна.

Академич Ринчен, “Цогт Тайж” кино зохиолоороо Маршал Чойбалсангийн нэрэмжит шагнал хүртсэн тухай “Үнэн” сонины 1946 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 33 дугаарт бичихдээ:

“1946 оны 2 дугаар сарын 8.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 10 дугаар хурлын тогтоолоор “Цогт Тайж” гэдэг уран сайхны кино зохиол зохиосон Бямбын Ринчен... нарт тус бүр Маршал Чойбалсангийн нэрэмжит II шагнал олгожээ” гэсэн байна. “Утгазохиол Урлаг” сонины 1978 оны 5 сарын 12-ын №20 (1121) дугаарт дахин мэдээлсэн.

Маршал Чойбалсангийн нэрэмжит шагнал авчихаад, лэгий нэгдгүй тоолоод суугаад байсан юм гэнэ лээ, ганц дэвсгэрт авч өвөртөлчхөөд бусдыг нь Ленинградын өнчин хүүхдэд бэлэглэхсэн юм гэнэ лээ гэсэн домог мэт яриа байдаг. Үнэхээр, шагналынхаа 15 мянган төгрөгийг, Ленинградыг хамгаалж байгаад нас барсан дайчдын ар гэрийнхэнд тусламж болгон илгээсэн, хариу талархлын бичиг ирсэн тухай баримт бий, үүнд “Үнэн” сонины 1946 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 129 дугаарт бичихдээ:

“Маршал Чойбалсангийн нэрэмжит шагнал авсан зохиолч Б.Ринчен шагналынхаа 15 мянган төгрөгийг Ленинградыг хамгаалж байгаад нас барсан дайчдын ар гэрийнхэнд тусламж болгохоор, Ленинград хотын Зөвлөлийн Хөдөлмөрчдийн депутат нарын Гүйцэтгэх Хорооны дарга нөхөр П.С.Попковын нэр дээр гуйвуулжээ. “Энэ мөнгө нь, Улаан армийн амь үрэгдсэн байлдагч, офицер нарын 52 ар гэрт боломжтой дэмжлэг үзүүлэх бололцоо өгөв” гэж хариу талархлын цахилгаан утас ирүүлжээ” гэсэн байна. “Утгазохиол Урлаг” сонины 1978 оны 5 сарын 12-ын №20 (1121) дугаарт дахин мэдээлсэн.

1946 он гэдэг ямар цаг билээ! Хоолой давахгүй хар гурил шигшиж идэж байсан газар ч бий. Тийм цагт тийн сэтгэж, түүнийгээ биелүүлнэ гэдэг бол тэр болгон, хэн хүнд байгаад байдаг шинж биш, үл умартах нандин түүх. Энэ нь, Академич Ринчен хар амиа боддоггүй, өр зөөлөн (~~өр зөөлөн~~ öri jögele=өрөвч), элсэг сэтгэлтэй, монголоороо зогсохгүй, дэлхийн хэмжээнд сэтгэдэг байсныг тодоос тод харуулна.

Баруун германид хэвлүүлсэн цуврал бүтээлийнхээ шагналаар хэвлэлийн машинууд худалдаж аваад, ШУА-ийн хэвлэх үйлдвэрт сохор зоос ч авалгүй хүлээлгэж өгч байсан. Ийм хүн одоо болтол манайд гараагүй. Түүгээр олон мянган ном хэвлэсэн. Монгол бичгийн хэлнийзүйн нэг боть хураагдаж, төлбөр гарахад, хэвлэх үйлдвэрийн дарга Д.Содномсамбуу гуай “Би л лав Ринчен гуайгаас төлбөр нэхэж зүрхлэхгүй. Манай энэ сүүл үсийн машинуудыг чинь Ринчен гуай бидэнд зүгээр өгсөн юм шүү дээ. Тэхдээрээ тулвал, бид харин Ринчен гуайд өртэй гарна шүү” гэж хэлсэн гэдэг.

Академич Ринчен, хүн юм асуувал, ёстой онгод нь ордог хүн. Эрдэмт хүний төрмөл төрх тэр. Нүд нь гялалзаад, нүүрнийх нь үрчлээ арилаад, духасхнийснээ ярьж гарна. Залхуурахыг мэдэхгүй, цагаа хайрлана гэж байхгүй, эрхийгээ эргэлдүүлэнхэн солиболзууланхан наадуулж, бодолхнийгэн, намуухнаар ярина. Дуу хураагуурт шингээж аваад, юмаар юм хийж чаддаг хүнд бол хэд хэдэн “диссертаци” даа.

Танхимд шуугиантай бол зориуд дуугаа намсгана. Ярьж, хөөрч байхад нь ялаа нисэх сонсогдом.

- Бэлэн зэлэн гэдэг нь яана. Нэгэн орчуулагч, утсаар “Дни и ночи” гэдгийг “өдрүүд, шөнүүд” гэж орчуулах уу гэж асуусан гэдэг. “Өө, тэр чинь монголоор “Өдөржин, шөнөжин” гэсэн утгатай гэж харуулсан, тэгээд зохиолын нэрийг тийн өгсөн гэдэг.
- Багш бол, бусдыг бишрүүлэх удистай нэгэн. Хэлний хүрээлд “Их, бага сахалт” гэж алдаршсан, оросын хоёр эрдэмтэн нэг одор гэрт нь очиход, багш эртний орос, славян, баруун зүгийн хэлний үгийг ашиглан ярилцсанд туйлаас биширсэн гэдэг.
- Профессор Чой Лувсанжав ярихдаа: - Бээжинд сурч байлаа. Ринчен багштан морилон ирэв. Би шавь нь болохоор орчуулга хийнэ, хятад хэл “мэднэ” маягийн юм бодоод хэдэн өдөр дагалаа. Нэг өдөр, Хятадын Шинжлэх Ухааны Академи дээр очдог байна. Ринчен багштан яриан дундаа “Монголчууд хятадын ном соёлыг эртнээс сайн мэддэг, “Шүтэглэлт Ном”, “Ачлалт Ном”, “Хүйтэн Уулын бичиг”, “Жинпинмэй бичиг” зэргийг монгол орчуулгаар уншидаг байсан гэж хэллээ. Нөгөө оовлож байсан Би гэдэг хүн таг суучихдаг байгаа. Тэгсэн чинь харин Багштан дээрхи номын нэрсийг хятадаар, Бээжин аялгуугаар цэвэрхэн хэлчихдэг байна шүү. Би дотроо их биширч багшаараа бахархаж байлаа. Ээ дээ Сумьяа минь хэл мэднэ гэж онгирч л болдоггүй юм билээ шүү гэж захисан удаатай.
- 1956 онд юмдаг. Бээжингийн их сургуулийн оюутнууд, солонгосоос буцаж явсан бид хэдэн оюутантай Тэнгэр сүмийг үзээд буцаж явахдаа Багш - Чингис хааны Их Өчигт “Цагаан солонгос мину” гэж гардаг, манайд төрийн их ятга гэж байсан, солонгосоор “Каяагым” гэдэг байх аа гэж хэлэхэд нь бид хэд мэл гайхаж, цэл хөхөрсөн. “Их Өчиг” байтугай, нэг жил нутагт нь солонгос хэл үзээд яваа бид нар тэр хөгжмийн нэрийг ч халтчих төдий. Солонгост сураагүй, бичгээр үзсэн хүн бол, “Каяакым” гэх ёстой. Гэтэл, яг солонгос хүний дуудлагаар “Каяагым” гэж цэвэрхэн хэлсэн нь гайхашруулж билээ.
- 1959 онд Олон Улсын Монгол Хэлбичгийн эрдэмтний анхдугаар Их Хуралд оролцож, “Солонгос монгол хэлний харьцаа” гэдэг илтгэл тавьсан академич Хон Гимүнь багш эргэж очоод бидэнд “Олон Улсын Хуралд очоод, илтгэл тавиад ирлээ. Профессор Ринчен гэдэг хүнтэй танилцлаа. Их өргөн ханцуйтай монгол дээл өмсдөг хүн хараглав. Хятадаар ярихгүй юм, бичгийн хятад хэлтэй

бололтой, гаш цэгэн үг хатгаар бичиж байна лээ. Бил эхеранги хэлээр нэвтрэлцэж байлаа” гэж ярьж билээ.

Ринчен багштанга, олонтой үг сурч байсан.

Проф Н.М.Онашин "Китайско-Русский словарь 1955 он"

Фонетический указатель, 194-р талын зураг.

Ринчен багш, шавь олонтой. Бараа дүрний нь харж, дуу хөстөйт нь сонсож, ном тавихы нь мэдэгсэд - нэгэн хэсэг шавь бий. Гэд даанч цөөрч дээ, хөөрхий. Уулзаж учраагүй боловч, сургаал номыг нь дагагсад, сургаар бичиргэсэд хөг хөдөөгүй, мундахгүй олоон. Тэд харин, цөөрөх шинжгүй, олохдох боловтой. Ринчен багш, шавиа гэж хоосон магтаж дөвийлгөдөггүй, заримдаа бүр "Билсэн дүрэн Билсэн жинсэн", "Милэйн үгс гашаа сургаал Эгэн хэл мэлэйн сургаал" шүүн тэмдэг, 26-26-р дүгнэлтийг нь яана. Тэрхүү, олгондоо хагуу, хошин шог, хор шар хөдөлгөсөн аятай үгс нь, тусгаж авдаг хүндээ тус болж байв уу гэхээс, ус болж байгаагүй гэж санаана. "Шүүмжийн үзүүрт сүү" гэдгийг ойлгодоггүй зарим нь баяхан тэмдэгдэг л байсан байх аа.

Академиа Ринчен багштан бол, ном бүтэхийнх нь оо сгийнг дэрж, гэрч болох алдвар (← aldaburi - алдаа)-аас нь сэрнийлэн зовдож байв уу гэхээс биш, хүнийг, буслыг муу хэлдэггүй хүн байсан юм шүү. Өрөө танхим, хөдөө талдаа, гэр орон, гудамж талбайд олонтаа уулзаж, Хөвсгөл иймд мориноос унаж, духад шатбалахад нь хүртэл цусыг нь аччуургаа шингэж авч, хойно

өмнө нь бөртгөнөж явсан миний бие тиймэрхүү үг огт сонсоогүй, дуулаагүй. Үүнийг залуу ажилтан нарт өгч байсан сургаал сургамж, бодот баримтын жишээн дээр өгүүлнэ:

1) Би бол, Академич Ринчен¹тэй зуун метрийн доторх агаараар амьсгалж, зуз (≡) байсан **гамгат шавь**² нь. Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн 1967 оны 3-р сарын 17-ны өдрийн 26/3 тоот тогтоололтр, туслах ажилтан намайг академич Ринченд албан ёсны шавь болгож өгсөн удаатай. Ирэх жил хагас зуун жилийн ой нь тохноно.

Энэ бол, надаа, академич Ринчен¹ий нэрэмжит анхны шагнал мэт санагддаг. Албан бичиг хуурамчаар үгсддэггүй л юм бол, ахиад торохгүй. Хальтрах цагт минь “үтгын таяг” болон түшиж, үүгээр би өөрийгөө иртэж явдаг хүн. Багштан айлдахдаа: “Та, намын хүн бальёо гэж бодож байгаа бол, худгийн мэдлийн үлгэрийг байнга санаж явагтун. Хаана юу гарсныг мэдэхгүй бол сохор номин адил. Ядаж Дурсгалт бичгийн Чуулган, хүрээлэнгийнхээ цувралаар гарсан зүйлийг нэг цэгцэлчихвэл сайнсан (Багшийнхаа айлдсаны дагуу тэр дор нь хийж хэвлүүлсэн). Улсын намын санд гарбичмэл зүйл их байгаа. Төгсгөлийн үгийг нь утгиваас эзэн бие нь тодордгийм. Номын санд бөгсөө хавтайтал суувал насны хоолтой болно. Дагва, Малам гэж, нүдээ аньж байгаад ч хаа юу байгааг алдог, зэрэг цалтнуудын зэрэг цалгүй багиг нар байгаа. Тэдэн дээр очигтун. Миний нэрийг хэлээд очсон ч болно. Гандан хийд гэж нэг намын орон буй. Та, одоохондоо шонгүй биз (Төвд хэл үзвэл сайн гэсэн санаа цухалгаж байв.

¹ Шавь шавь гэх нь ч яахав. Амтай бүхний өмнөс унаж болох л үгс. Багшийнхаа тухай юу хийв гээг нь чухал. Сүүлийн үед бүтээл туурвилыг нь боть ботиор нь эмхэтгэн хэвлэх, галын дөлөөр агаарт одож өгторгүүд халгалагдсан зарим зохиол, бараг “ардын” болчихсон сонин сэтгүүн яриа хоорног нь хүртэл нийтийн хүртээл болгож, адлагдаж асан Багшийг минь дээдэн буй нь юутай сийшаалтай. Мөхөс шавь би-бээр, гар бичмэл, өдрийн тэмдэглэлийн улбааг мөшгөн, Багшийнхаа “*Төсөн дурыг хороологүй, сүүн зүрхийг ээдуулаагүй*” (Нууц товчоо, 254-р зүйл), ил болоодүй дотоод ертөнцийг нь нээх зам чийр сүвэгчлэх ядргаа, Б.Ринчений “Монгол хэл” шүлгийн солонгос орчуулга. 1991 он. Сөүл, “Академич Ринчений жарал дөрвөн настай гар бичмэл” (МУИС, Эрдэм шинжилгээний бичиг. 2001, 17-р боть. 4-р дэвтэр, х.76-84), Академич Ринчений “Сказатели и сказочники у монголов” (Чингисийн алтан ургийн Угийн бичиг ба Гэрийн үеийн бичмэл.Уб., 2002, х.634-715. Анх удаа хэвлэгдсэн нь энэ. Э.Пүрэвжав нар дам авч, эмхэтгэлд нь оруулсан!); Академич Ринчений “Миний монгол хэлээр орчуулсан зүйлийн жор, саяг тодорхойлох нь Гэгээхүү шайтлуулсныг дурдай. Чингэлэн, бас, харахан бүрэн бус” санаа гар бичмэл нь *Орчуулсан тайлбар* талы.1-5-р дэвтэр.Уб., 2005, х.50-82. Анх удаа хэвлэгдсэн нь энэ. Олон хүн үүгээс шоолборлон хуулж, бүртгэлд оруулсан буй); “Туулин утг монгол угаа” (Академич Ринчений мэндэлсний 110 жилийн ойд зориулав). Сөүл. 2015. Эмхтгэл. pp.159-168; “Хубилай Их Хааны үеийн монгол + солонгосын харилцаа”. Ганц сэдэв зохиол. (*Академич Ринчений мэндэлсний 110 жилийн ойд зориулав*.Уб., 2015, х.530. “Академич Ринчений “Монгол хэлний бүртгэл” гэдэг бүртгэлийг хэвлэгдэн и” Ерөнхийлөгчин нвээл дор болсон, олон улсын эрдэм шинжилгээний хурал. ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн. Эмхтгэл. Уб., 2015., “Хубилай Их Хааны үеийн монгол + солонгосын харилцаа”. 2015, х.61-91. зэргийг тус тус хэвлүүгээд байгаа ба, энэ удаа “Академич Ринчен бол, хүний төлөө төрсөн хүн” гэсэн номныхоо хэсгээс толилууцж байнам.

- Асууж ч дуусдаггүй, зэмлүүлж ч халширдаггүй хоёр хүн байсан нь М.Шинэхүү бид хоёр доо. Тэр үед чинь хийсэн зүйлээ хэвлүүлэхийн өмнө нэрт эрдэмтдэд үзүүлж, зөвлөгөө авч, зөвшөөрөл хүсдэг тогтсон зарчимтай.
- “Монгол хэлний ойролцоо үгийн товч толь”-оо бариад нэг өдөр очив. “Өөр, ондоо, өшөө” гэдэг үгсийг ойролцоо утгатай гээд оруулчихсан чинь, ээ бурхан зүг орой дээрээ, Багш “өшөө” гэдэг чинь орос хэлний “еще” гэдэг үг. Нугалааны үед орж ирсэн гээд л, нөгөө нооргуудыг чинь ёстой улаан алаг болгоод огдог байгаа. Тэр дагуу нь засаад, хэвлүүлчхээд бариад очтол, авч үзсэнээ, “үсгийн дүрэм нь л жаахан жогорхойтой болждоо, хөөрхий. Монгол бичгээрээ хадаад өгсөнсөн бол юутай сайн. Анхны толь юм даа” гэж хэлж билээ.
- 1967 онд, Хэл зохиолын хүрээлэнгийн номын сангийн тэмдгийг Судар хэлбэртэй, монгол үсэг шинэ үсэг хоёроор хавсран хийгээд очсон чинь харин “Монгол нь өмнөө орсон нь зөв” гэж нэлээн таашаасан байдалтай, засч өгсөн (Зарим хүн, албан газрын санаанд төдийлөн нийцээгүй бололтой, гадагш явуулсан номон дээрээ дарчхаад хэл аманд орж л байлаа)

20.7
 үсгийн
 дүрэм
 нь шинэ
 үсэг
 1967.



Монгол
 үсэг
 Номын
 сангийн
 тэмдэг

The logo consists of a circle containing a stylized illustration of a book spine. Below the circle, there is a rectangular box containing the number '17'.

Академик Ринчений зааварласан

“Хэл зохиолын хүрээлэнгийн Номын сангийн тэмдэг”

2) 1968.4.19. Баасан. 14³⁰ Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн хурал 460-р өрөөнд болов (Протоколын сийрүүлэг). Академич Ринчен Б. Содном гуайн өвдөөс хараад сүүж. Хар ботинкатай, саарал костюмтай, хар имжээртэй, хүрэн хилэн дээлтэй, энгэр дээрээ: ногоон улаан ногоон, буурал цагаан буурал, ногоон цагаан ногоон, улаан хөх улаан өнгийн 4 одонгийн тууз зүүсэн байв. Энэ хурал дээр "Нутгийн ахлууны Атлас"ын тухай яриа болоход Ринчен багш:


- Атласыг хэвлэлийн төлөвлөгөөнд 1 хх гэжээ. "Боть" гэдэг чинь 1 хх байдаггүй шүү дээ. Учир мэдэхгүй болохоороо тэр. Хаана хасчихсан юм бэ?
- "Искусство рассказчиков" гэдгийг бичихэд, оросоор бичихэд, бас цаг их орох нь ээ. Улирал нь хоёр гэж байвуу? гэсэн яриа өрнөж байхад, Д.Цэрэнсодном орж ирж, Чойжи-Одсэрийн тухай ярианд шилжив. Ринчен багш, Д.Цэрэнсодномд дараах зөвлөгөөг өгөв:
- "Шүлгийн тогтолцоог Та гаргах болох нь ээ дээ. Тайлбары нь бичихдээ ямаршуу үзлийн үүднээс бичих вэ? Онол нь байна уу?... Уг нь сайхан. Бас нохойтой ажил байна. 13-р зуун гэвэл, Ижил мөрний үйсэн дээр бичсэн шүлэг байсан. Поппе бичсэн, орчуулаад, шүлгийн тухай нь паг суучихсан шүү дээ. Чойжи-Одсэр бандида хүн. Энэдхэгийн дээд математикийн юмыг бага сургуулийн тооны хүн дийлнэ гээд дайрахтай адил болох буй заа гэж би зовнам. Огалын мэдлэг л нимгэдэх боловуу гэж бодно. Би тэр Чойжи-Одсэрийн шүлгийн тогтолцоог олчихно гэдэгт ч би итгэхгүй байна. Монгол улсаас хиймэл дагуул хийгээд, сар руу хөөрнө гэсэн тэй адил юм болно. "Системность монгольских стихотворений" гэдэг нь умаахан болчихно доо. Шүлэг нь ямар байдгийг хэн ч хөндөөгүй байна. Таны тэр юм чинь "Обо всем мне о чем" болчих гээд байгаа юм. Ижийгээс гарсаар л хурим хийнэ гэсэн юм л болчихно доо. Миний багш Владимирцов "Үхсэн хойноо яс чинь хавтайх юм битгий хий" гэж захьдаг байсан. Дараагийн юмандаа ... нямбай бай. Муу, бүдүүн үс багтахгүй байхаар. Энэ нарийн нямбай гэдэгтэй холбоотой. Их нямбайлж байгаарай" гэж захив.

3) Д.Цэрэнсодномыг Мажарт явуулах тухай хэлэлцэхэд, Ринчен багш:


- Явуулъя. Над нэг хүсэлт байна. Тэнд чинь хэвлэл сайн. Явахынхаа өмнө эндхийнхээ хэвлэлийн чадалтай танилцаад явбал сайн юм. Тэндэхийн юмыг сураад ирэхээр, энд ирээд бүтэлгүй болчихно шүү гэж зөвлөв.

1988.09.19. Баасан 190 L

Хүний эдийн засаг
 Мэрг, Үйлдвэр, Хөдөө аж-агуй
 Хүний эдийн засаг нь улс
 бүхийгээр өргөтгөл болно



1. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
2. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
3. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
4. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
5. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно



Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
 Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
 Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно

1. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
2. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
3. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
4. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
5. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно

1988.09.19. Баасан 190 L

1. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
2. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
3. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
4. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
5. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
6. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
7. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
8. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
9. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
10. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно

1. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
2. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
3. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
4. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
5. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
6. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
7. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
8. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
9. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно
10. Хүний эдийн засаг нь улс бүхийгээр өргөтгөл болно

Халхнолын хуралынгийн Эрднийн Зөвлөлийн хурлын протоколын дээр хэсэгчлэн сийрүүлсэн ноор. 1988.4.19. Баасан 140